

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГАД НЭР
ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН**

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга

1 **Эцэг/эхийн нэр:** Түндэв
Нэр: Жамбаажамц
Хүйс: Эрэгтэй
Нэр дэвшүүлсэн байгууллага: Улсын Их Хурлын дарга

2 **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**

Санхүүгийн зохицуулах хорооны дарга

Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.

1/Нэр дэвшигч Түндэвийн Жамбаажамц нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, сононзnews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

4/Мэдээллийн дагуу сонсголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Т.Жамбаажамц нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Г.Лувсанжамц, Х.Ганхуяг, Л.Соронзонболд, П.Сайнзориг, Ч.Лодойсамбуу, Э.Батшугар, Дав.Цогтбаатар, Д.Энхтүвшин, Б.Жаргалан нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай: Иргэд аливаа нэг компанийн хувьцааг худалдан авах тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагаа, санхүүгийн мэдээ тайлан, хувьцааны талаарх мэдээлэл дутмаг байдгаас хувьцааны арилжаанд оролцож чаддаггүй тул иргэдийг мэдээллээр хангах чиглэлд хэрхэн ажиллахаар төлөвлөж байгаа талаар;

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц: Жолоочийн хариуцлагын даатгалаар жишээ авч үзэхэд даатгал гэдэг нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахаас гадна хүлээх хариуцлага байдгийг олон нийтэд ойлгуулах чиглэлд Санхүүгийн зохицуулах хороо ямар ажил хийх, хөрөнгийн зах зээл дээр зөвхөн стратегийн хөрөнгө оруулагчдыг хамгаалж байгаа нь учир дутагдалтай болохыг дурдаад хөрөнгийн зах зээлийн үндсэн оролцогчид болох жижиг, дунд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг төлөвлөсөн талаар;

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг: Банкны тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр арилжааны банкнууд 2026 онд багтаан хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгох, Санхүүгийн зохицуулах хороо банкнуудын хувьцааг олон нийтэд болгох, урт хугацааны хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулах, санхүүгийн зах зээлийг илүү чөлөөтэй болгож, өрсөлдөөнийг дэмжих хүрээнд даатгалын эрх зүйн орчныг хэрхэн сайжруулахаар төлөвлөж, даатгалын тухай хууль тогтоомжийн төслийг хэзээ шинэчилж, өргөн мэдүүлэхээр төлөвлөж байгаа талаар

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Хөдөө орон нутгийн иргэд малын индексжүүлсэн даатгал гэх мэт санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг жигд хүртээмжтэй авч чаддаггүй тул иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, орон нутгийн иргэд бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, Санхүүгийн зохицуулах хорооны бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдыг татахад ямар арга хэмжээ цаашид авах талаар;

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг: Компанийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаа хоорондоо зөрчилтэйн улмаас төрийн өмчит компанийн ногдол ашиг хуваарилахад хугацаа алдаж байгаа тул жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад ямар арга хэмжээ авах, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс зөвшөөрөлгүй, бүртгэлгүй мөнгөн зээл олгож байгаа этгээдүүдэд тавих хяналт, малчдын зээлийг тэглэх гэх мэт банк, санхүүгийн салбарыг эрсдэлд оруулахуйц үйл ажиллагааны эсрэг баримтлах байр суурь, тус хорооны шийдвэр гаргах процессын удаан, хөшүүн, ерөнхийлсөн шийдвэр гаргадаг байдлын эсрэг юу хийх, банк, санхүүгийн салбарынхан иргэдийн хувийн мэдээллийг задруулдаг үйл ажиллагааны эсрэг ямар арга хэмжээ авах талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу: Хуульд заасны дагуу Улсын Их Хурлын дарга санал болгосноор Санхүүгийн зохицуулах хорооны даргын албан тушаалд нэр дэвшүүлдэг тул Монгол Улсын Их Хурлын даргыг таньдаг эсэх, таньдаг бол хэзээ, хэрхэн танилцсан талаар, Монгол Улс дахь хөрөнгийн зах зээл, гадаад хөрөнгө оруулалтын орчин таагүй байгааг юу гэж оношилж байгаа талаар, виртуаль хөрөнгө худалдан авсан, крипто валютад хөрөнгө оруулсан этгээдүүдийн хөрөнгийг үнэгүйдүүлэхийн эсрэг дэлхийн жишигт нийцсэн ямар арга хэмжээ авч ажиллах талаар,

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар: Санхүүгийн зах зээл дэх ил тод байдлыг сайжруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгийн биржийг олон улсын сайн жишигтэй дүйцүүлэн хөгжүүлж, өндөр үр өгөөжтэй хөрөнгө оруулагчдыг татах, Евро Азийн биржийн холбоонд Монгол Улс нэгдэх, хувьцааны биржийн арилжааг ил тод болгох, цахимжуулах зэргээр хялбаршуулах асуудлаар;

Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар: Монгол Улсад хөрөнгийн бирж дээр бизнесийн журмаар хөрөнгө босгох үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүд маш ховор, зөвхөн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүд жижиг зээл олгодог, мөн өөрийн үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа эрхэлж ашиг орлого олж байгаа хуулийн этгээдүүд болон жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар яагаад өнөөг хүртэл дорвитой ажил хийхгүй байгаа, үл хөдлөх эд хөрөнгөө даатгуулсан этгээд даатгалын нөхөн төлбөрийг бодитой авч чадаж байгаа эсэх, даатгалын зах зээлд олон улсын сайн жишгийг яагаад зөв буулгаж, хэрэгжүүлж чадахгүй байгаа, дотооддоо мөнгө угаах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагааг хангалттай явуулж чадаагүй байгаа талаар, Санхүүгийн зохицуулах хорооны даргаар томилогдсон тохиолдолд өмнөх удирдлагуудаас ялгаатай ямар үйл ажиллагааг хэдий хугацааны дотор хийж гүйцэтгэх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин: Монгол Улсад мөнгө угаах гэмт хэргийн хууль зүйн агуулгаас хамаарч бизнес эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын зарим үйл ажиллагаа шууд гэмт хэргийн шинжтэй гэж тодорхойлогдож байгааг хэрхэн үзэж байгаа талаар, эрсдэлийн түвшнээс нь хамаараад үүнийг өөрөөр зохицуулж болох эсэх;

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан: Зээлийн хүүгийн хэмжээг хэрхэн бууруулах, зээлийн хүү, шимтгэлийн бодлогыг цаашид хэрхэн тодорхойлох, нэр дэвшигчийг ажиллаж байх хугацаанд Монгол Улсын санхүүгийн зах зээлд үүссэн саарал жагсаалт, крипто валютын эрсдэл, жолоочийн хариуцлагын даатгал зэрэг иргэддээ санхүүгийн мэдлэг, мэдээлэл олгоогүйгээс үүссэн сөрөг үзэгдлүүд нь одоогийн нэр дэвшигчийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох гэсэн зорилготой хэрхэн уялдаж байгаа, үүнтэй холбогдуулан хууль тогтоомжийг сурталчилж, бизнесийн орчныг дэмжихэд Санхүүгийн зохицуулах хороо ямар үйл ажиллагаа явуулж байсан талаар, хөрөнгийн зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчид багассан тул хөрөнгө оруулагч татах, жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд ямар шийдэл гарган ажиллах талаар асуулт асууж, хариулт авлаа.

8/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин жижиг бизнес эрхлэгч компаниуд заавал томоохон компаниудтай бизнес эрхлэхэд өрсөлдөхгүйгээр тэдгээр компаниудад хөрөнгө оруулалт хийдэг байх боломжийг нээхтэй холбоотой үйл ажиллагааг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл тус албан тушаалд томилогдсон тохиолдолд авлигыг бууруулах, хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд сайн засаглалын зарчмуудыг хангаж ажиллах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж зээлийн хүүгийн хэмжээг бууруулах, иргэд орлого хангалтгүйгээс болж банк бус санхүүгийн байгууллага болон бусад хувь хүн, байгууллагаас зээл авдаг нөхцөл байдалд анхаарал хандуулах, цахим мөрийтэй тоглоомыг хязгаарлах арга хэмжээг авах шаардлагатай байгаа талаар үг хэлсэн болно.

9/Сонголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

10/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	<p>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус</p>
----------	--

	<p>тус баримтлан Нэр дэвшигчийн сонголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайланг гаргалаа.</p>
4	<p><i>/Байнгын хороо цуелуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны даргад нэр дэвшигч Түндэвийн Жамбаажамц нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:</p> <p>1/Нэр дэвшигч Санхүүгийн зохицуулах хорооны даргаар томилогдвол:</p> <p>Хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн орнуудын санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллагууд, томоохон хөрөнгийн биржүүд болон хөрөнгө оруулалтын сангуудад урт, дунд хугацааны мэргэшүүлэх хөтөлбөрүүдэд удаа дараа хамрагдаж, мөн салбар тус бүрийн хяналт зохицуулагчдыг нэгтгэсэн олон улсын байгууллага, нийгэмлэгүүдтэй хамтарч ажиллаж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, туршлага солилцсоноор санхүүгийн зах зээлийн зохицуулагч төрийн институтийн онцлог, чиг үүрэг, эрх хэмжээ, хандлага, соёл гээд олон зүйлүүдийг газар дээр нь танилцаж, мэдрэн, практик туршлагыг тодорхой хэмжээнд цуглуулж ажилласан хүний хувьд цаашид өнөөгийн санхүүгийн зах зээлийн ололт амжилт, өсөлтийг хадгалах, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг олон улсын жишигт нийцүүлэн үргэлжлүүлэн хөгжүүлэх, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах илүү ухаалаг санхүүгийн зах зээлийн орчинг бүрдүүлэх зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай гэж үзэв:</p> <p>Санхүүгийн зарим үйл ажиллагааг зохицуулж буй одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль 2002 онд батлагдаж, нэмэлт, өөрчлөлт 12 удаа, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 2011 онд батлагдаж, нэмэлт, өөрчлөлт 4 удаа, Даатгалын тухай хууль 2004 онд батлагдсан, нэмэлт, өөрчлөлт 17 удааг тус тус орсон. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох, салбарын өсөлтийг нэмэгдүүлэх хүрээнд эдгээр хуулиудыг шинэчлэх зайлшгүй шаардлага практикт бий болсон гэж үзэж болохоор байна. Мөн технологид суурилсан санхүүгийн шинэ үйлчилгээ бий болж, салбарын харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэн, зах зээлд тэлэлт явагдаж байгаатай холбогдуулан хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалсан, хөрөнгө оруулалтыг татах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн, салбарын хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлсэн эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна. Иймээс салбар тус бүрийн эрх зүйн орчныг шинэчлэлийг хийж, хөрөнгө оруулагч, харилцагч, үйлчлүүлэгчийн эрх ашиг хамгаалагдсан, тогтвортой, зардал бага, үр ашигтай санхүүжилтийг тогтолцоог үргэлжлүүлэн хөгжүүлэх, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад таатай, итгэл</p>

хүлээсэн санхүүгийн зах зээлийн тогтолцоог бий болгох бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тухайлбал, дотоодын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох, хөрөнгө оруулагчдад таниулан сурталчлах, хөрөнгийн зах зээлд оролцох идэвх, сонирхлыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлэх шаардлагатай. Зах зээлийн эрх зүйн орчин олон улсын жишигт нийцсэн таатай, тогтвортой байхаас гадна шаардлага хангахуйц бүтээгдэхүүн, үйлчилгээтэй, хөрвөх чадвар сайтай хөрөнгийн зах зээлтэй улс оронд дотоод, гадаад хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулах сонирхолтой байдаг. Хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, зохицуулалттай зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 онд баталснаар хувьцааны хамтын санхүүжилт, хадгаламжийн сертификат, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ зэрэг санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Иймд эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой нарийвчилсан процессыг зохицуулах журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, батлуулах арга хэмжээг төлөвлөж байхаас гадна томоохон аж ахуйн нэгжийн үнэт цаасыг хөрөнгийн зах зээлд нээлттэй арилжаалах боломжийг бодлогоор дэмжих ажлыг гүнзгийрүүлнэ. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын хөрөнгө оруулалтын сан, даатгалын компани, банк, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны компаниудын идэвхийг нэмэгдүүлж, урт хугацааны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох тогтолцоог бэхжүүлэх, ногоон буюу байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, зах зээлийг бий болгох хүрээнд хөрөнгө оруулалтыг татах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгоно. Үүнээс гадна Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлж, хөрөнгийн зах зээлийг төрөлжүүлэн үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулагчдад илүү хүртээмжтэй, эрсдэл багатай байдлаар санал болгох тогтолцоог бүрдүүлэхээр ажиллана.

Мөн Даатгалын зах зээлийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг бүтэц, төвлөрлийн хувьд дүгнэвэл ердийн даатгал давамгайлсан буюу нийт хураамжийн орлогын 99.0 хувийг ердийн даатгалын хураамж эзэлж байгаа эзэлж байна. Харин даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д даатгалын хураамжийн орлогын эзлэх хувь 0.58 байгаа нь дэлхийн дунджаас даруй 11-12 дахин бага, нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ буюу даатгалын нягтрал 113,377.4 төгрөг байгаа нь дэлхийн дунджаас даруй 20-30 дахин бага байна. Эдгээрээс харахад даатгалын салбарын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын даатгалын зах зээлийн чиг хандлага, хөгжилд гарч буй өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан техник, технологийн хувьсгалд нийцүүлж хөгжүүлэх, олон тулгуурт салбарыг бий болгох, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам боловсронгуй болгох арга хэмжээнүүдийг төлөвлөж ажиллана.

Хадгаламж, зээлийн хоршооны зах зээлийн найдвартай байдал болон хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахын тулд дэлхийн улс орнууд хамгаалалтын 2-3 давхарга бүхий тогтолцоог бий болгох жишиг тогтсон байна. Олон улсын чиг хандлагад хадгаламж хамгаалалттай холбоотой асуудалд хадгаламж, зээлийн хоршоодыг банкны салбарын нэгэн адил зохицуулахад чиглэж байна. Хадгаламж хамгаалах тогтолцоог нэвтрүүлснээр зах зээлд орох

мөнгөний урсгал нэмэгдэх, гишүүдийн тоо өсөх, иргэдийн хадгаламж, зээлийн хоршоонд, цаашлаад зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд эерэг нөлөөтэй тул санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажил тэргүүн ээлжид тавигдаж байна. Манай орны хувьд хадгаламж, зээлийн хоршоод хамгаалалтын нэгдүгээр давхаргын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 3 давхаргат хамгаалалтын тогтолцоог нэвтрүүлэх, салбарын нэгдсэн дэд бүтцийг бий болгох зохицуулалтаас гадна засаглал, санхүүгийн тайлагнал, цахим шилжилт, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтуудыг нэвтрүүлснээр зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг гүйцэтгэх шаардлагатай байх тул уг хүрээнд хадгаламж, зээлийн хоршооны салбарыг хөгжүүлэх бодлого барьж, үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Банк бус санхүүгийн салбарын хувьд сүүлийн жилүүдэд технологид суурилсан санхүүгийн шинэ үйлчилгээ бий болж, салбарын харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалсан, салбарын оролцогчдыг чадавхжуулж, санхүү, төлбөрийн чадварыг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн төрөлжсөн мэргэшсэн институт болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд учрах санхүүгийн ачааллыг бууруулах зорилгоор тус зохицуулалтын орчинг олон улсын жишигт нийцүүлэх хэрэгцээ бий болсон. Иймд Банк бус санхүүгийн байгууллагыг эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн онцлог, эрсдэлийг харгалзан үйлчилгээгээр нь төрөлжүүлж, олон улсын жишигт нийцүүлэн “Зээлийн банк бус санхүүгийн байгууллага”, “Хөрөнгө удирдлагын банк бус санхүүгийн байгууллага”, “Факторинг”, “Валют арилжаа” гэж ангилан шалгуур, шаардлага, зохицуулалтыг ялгавартай тогтоох эрх зүйн орчны шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

Дээр дурдсан санхүүгийн тулгуур салбаруудаас гадна ФАТФ-аас тавьсан шаардлагыг биелүүлэх хүрээнд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч болон Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт эдлэлийн зохицуулалтын салбарын зохицуулалт болон хяналтыг Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг, бүрэн эрхэд хамааруулсан байдаг. Зохицуулалтад хамаарах эдгээр санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн үйл ажиллагааны хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зах зээлийн эрх зүйн орчинг сайжруулах, залилах болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг зохистой, хууль тогтоомжид нийцүүлэн явуулах, хөрөнгө оруулагч, харилцагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах зэрэг шаардлагыг харгалзан хяналт зохицуулалтыг эрсдэлд суурилсан тогтолцоонд бүрэн шилжүүлэх буюу бодит цагийн горимоор технологийн дэвшлийг ашиглан хэрэгжүүлэхэд бодлого, үйл ажиллагааг чиглүүлнэ.

Түүнчлэн Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас олон улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мөрдөх техникийн 40 зөвлөмжийг гаргасан ба уг зөвлөмжийн үнэлгээг сайжруулах чиглэлээр шуурхай арга хэмжээ авсны үр дүнд 2024 оны байдлаар ФАТФ-ын зөвлөмжийг бүрэн хангасан дэлхийн 5 дахь, ази, номхон далайн бүс нутгийн хэмжээнд анхны орон болсон. Монгол Улсын дараагийн шатны харилцан үнэлгээ 2027-2028 оны хооронд хийгдэхээр төлөвлөгдсөнөөс гадна харилцан үнэлгээг ФАТФ-ын шинэчилсэн аргачлалын дагуу үнэлэх тул тус харилцан үнэлгээг амжилттай хамгаалах бэлтгэл ажлыг хангахад зорьж ажиллана.

	2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Түндэвийн Жамбаажамцын ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргад тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.
--	---

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Булган Нэр: Саруул Хүйс: Эмэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:	
<p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.</p> <p>1/Нэр дэвшигч Булганы Саруул нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.</p> <p>2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.</p>	

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, sogonnews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

4/Мэдээллийн дагуу сонсголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Б.Саруул нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Р.Батболд Б.Жаргалан нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг: Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилогдсон тохиолдолд ямар зорилгын хүрээнд ямар ажлуудыг хийхээр төлөвлөсөн, хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаанд ямар ахиц дэвшил хийх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд: Монгол Улсад цаашид хөдөө аж ахуйн бирж байх шаардлагатай эсэх, түүхий эдийн арилжааг биржээр дамжуулан хийх боломж бүрэлдсэн эсэх, түүнд чиглэсэн ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн талаар,

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан: МҮХАҮТ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилогдсон тохиолдолд уг хоёр албан тушаалын чиг үүргээ хэрхэн уялдуулах, хөрөнгийн зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, санхүүгийн зах зээлийн салбарт жендэрийн хувьд ямар бодлого баримталж ажиллах талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

8/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл эдийн засгийг тэлэх хүрээнд авлигыг бууруулж, шударга өрсөлдөөнийг бий болгон, иргэдийн итгэлийг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг уг албан тушаалд томилогдсон тохиолдолд аливаа дүрэм, журмаар өрсөлдөөнийг хязгаарлах, хүнд суртал гаргахаас зайлсхийж, авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байж, ёс зүй, мэргэжлийн ур чадвартай ажиллах нь зүйтэй байгаа талаар үг хэлсэн болно.

9/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

10/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	<p>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.</p>
4	<p><i>/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнд нэр дэвшигч Булганы Саруул нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:</p> <p>1/Нэр дэвшигч Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнээр томилогдвол:</p> <p>Миний бие СЗХ-ны Үнэт цаасны газрын даргаар 2011 оны 10 дугаар сараас 2014 оны 05 дугаар сар хүртэл ажиллаж байсан бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, дагалдах журмуудыг боловсруулах ажилд гар бие оролцсон туршлагатай. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас (IOSCO) хөгжиж буй улсуудын зохицуулагчдыг хөгжингүй улсуудын зохицуулагч байгууллагад ажлын байран дээр дадлагажуулах, сургах хөтөлбөрт хамрагдаж, Санхүүгийн зохицуулах хороог төлөөлж Хонконгийн үнэт цаас, фючерсийн хороонд Үнэт цаас гаргах</p>

үйл ажиллагааг хариуцдаг Санхүүгийн газарт Ахлах менежерээр 2014 оны 06 дугаар сараас 2015 оны 06 дугаар сар хүртэл ажилласан. Энэ хугацаанд Хонконгийн бирж дээр үнэт цаас гаргах ажиллагааг хянан шийдвэрлэх, Хонконгийн хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд аудит хийх, тус хорооны Хяналт шалгалтын газрын шалгалтын багт орж ажиллаж туршлага хуримтлуулсан.

Улмаар Монголын компаниуд Хонконгийн хөрөнгийн бирж дээр хэрхэн хадгаламжийн бичиг гаргах талаар судалгааны ажлыг хийж, 2018 онд СЭЗИС-д Бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Иймд дээр дурдсан өөрийн ажлын туршлага, боловсрол, мэдлэгийг цаашид хөрөнгийн зах зээлийг Монгол Улсад үр дүнтэй, хүртээмжтэй хөгжүүлэхэд зориулан ажиллахдаа дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн болно:

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл хурдацтай өсөн тэлж ДНБ-д эзлэх хувь нэмэгдэж байна. Цаашид манай улсын хөрөнгийн зах зээл эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, компаниуд нээлттэй болж, хямд өртөгтэй хөрөнгө оруулалт татан өөрийн үйлдвэрлэлийг тэлэх, ажлын байр бий болгох боломж нөөц байна. Үүнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байна. Үүнд:

- Олон нийтээс хөрөнгө татах компани сайн засаглалтай, тунгалаг байх.
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг бүрэн хамгаалах, ингэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.2-д, 61.1.16-д заасны дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс Хороо хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно гэж заасан байдаг ч хэрэгжүүлж байгаагүй. Тухайлбал Хонконгд зохицуулагч байгууллага жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж шүүхэд хандах тохиолдол түгээмэл бөгөөд хэрэг шийдвэрлэх үйл явц мөн богино хугацаанд шийдэгддэг. Энэхүү арга хэмжээгээр дамжуулан тус салбарт олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт татан үнэт цаасны маргаан шийдвэрлэх чиглэлээр холбогдох байгууллагын чадавхыг бэхжүүлэх, цаашид өмчлөх эрхийн зөрчлөөс сэргийлэх боломжтой.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хадгаламжийн бичиг гадаад зах зээлд гаргах ажлыг дэмжих (одоогоор энэ ажил хийгдээгүй байна.)
- Хөдөө аж ахуйн биржийн ажиллагаа, төлбөр тооцоог олон улсын жишигт хүргэх, улмаар мах, буудай, хүнсний ногооны нийлүүлэлтэд фючерс гэрээг нэвтрүүлэх, ноос, ноолуурын арилжаанд фючерс, агуулахыг бичиг (warehouse receipts) зэрэг санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх.
- Миллениум Ай Ти програм нь хил дамнан үнэт цаас арилжаалах, төрийн өмчит компаниуд Монголын зах зээлд гарахад гадаадын хөрөнгө оруулагчид, тухайлан институциональ хөрөнгө оруулагчид саадгүй манай зах зээлд оролцох боломжийг бүрдүүлэх програм хангамж гэж анхлан танилцуулж нэвтрүүлж байсан. Иймд гадаадын хөрөнгө оруулалт татах боломжтой дотоодын томоохон компани нээлттэй болох эрх зүйн, техникийн бололцоог бүрдүүлэх, дээрх програм хангамжийг бүрэн хүчин чадлаар ашиглах.
- Тэтгэврийн реформыг үргэлжлүүлэх, институциональ хөрөнгө оруулагчдыг бэхжүүлэх зэрэг үнэт цаас төдийгүй, хөдөө аж ахуйн бирж, даатгал зэрэг салбарын хөгжлийг цогцоор нь дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Булганы Саруулын ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд

	үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.
--	---

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Лувсандорж Нэр: Сонор Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга: <p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.</p> <p>1/Нэр дэвшигч Лувсандоржийн Сонор нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.</p> <p>2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.</p> <p>3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:</p>	

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soronznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

4/Мэдээллийн дагуу сонсголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Л.Соноор нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, С.Цэнгүүн, Л.Соронзонболд, П.Сайнзориг, М.Мандхай, Ж.Алдаржавхлан, Р.Сэддорж нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц: Банк, санхүүгийн байгууллага, хөрөнгийн бирж, даатгалын тогтолцоонд ямар шинэчлэл хийх, Санхүүгийн зохицуулах хороог цаашид хэрхэн хянаж ажиллах талаар;

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн: Санхүүгийн зохицуулах хорооны хүний нөөцийн одоогийн нөхцөл байдал, хүний нөөцийн талаар баримталбал зохих бодлого, шинээр баг, хамт олон бүрдүүлэхэд хэрхэн анхаарах талаар,

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнээр томилогдсон тохиолдолд урт хугацааны даатгалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, иргэдийн даатгалын мэдлэгийг сайжруулах, даатгалын бодлогыг боловсронгуй болгох талаар ямар ажил хийх, орон нутаг дахь бизнес эрхлэгчдийг дэмжих, санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зээлийн батлан даалтын санг оролцуулах, батлан даалтыг ашиглах болон орон нутаг дахь банк бус санхүүгийн байгууллагууд итгэлцэл, бонд зэрэг санхүүгийн бүтээгдэхүүн гаргах нь харьцангуй хязгаарлагдмал байдаг тул үүнийг хэрхэн зохицуулах талаар,

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг: Иргэдийн өмчийг хамгаалах хүрээнд орон сууцны чанар стандарт, улсын комисс хүлээн авах ажиллагааг сайжруулах, орон сууцыг улсын комисс хүлээн авах ажиллагааг даатгалын системтэй хослуулах, бодлогын манлайллыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт татахад саад болдог төлбөрийн чадваргүйтлийн асуудлыг анхаарах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих хууль, эрх зүйн орчныг сайжруулах, албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүдийн тоог багасгах асуудлаар;

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай: Хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагддаг хувьцаат компаниудын хэд нь 25%-ийн хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалж байгаа, хуулийн этгээдүүд санхүүгийн тайлангаа үнэн зөв тайлагнасан эсэхэд Санхүүгийн зохицуулах хороо дүн шинжилгээ хийж, хууль бус үйлдлийг илрүүлэхэд чиглэсэн ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан: Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилогдсон тохиолдолд Сангийн яамнаас хараат бусаар олон нийтийн төлөөлөл болж ажиллаж чадах эсэх, хорооноос тусгай зөвшөөрлүүдийг олгоход авлигыг хэрхэн бууруулахаар төлөвлөж байгаа, холбогдох этгээдүүд банк бус санхүүгийн байгууллагуудын дүрмийн санг нэмэгдүүлж, үйл ажиллагааг хавчин шахдаг үйлдлийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар,

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж: Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд, хөдөө аж ахуйн компаниудыг дэмжих, хүнд суртлыг бууруулахад чиглэсэн ямар ажиллагааг хэрэгжүүлэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

8/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалдаг компаниудын мэдэллийг ил тод болгох, компанийн санхүүгийн тайланг үнэн зөв байдалд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөл дүн шинжилгээ хийж ажиллах талаар, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд санал болгож, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Алдаржавхлан уг албан тушаалд томилогдсоноор иргэдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд авлигыг бууруулахад ямар арга хэмжээ авах, банк бус санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироодог талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хувь хүний үйл ажиллагаанаас үл хамаарах цахим технологийг ашиглах, санхүүгийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхэд мэдлэг, туршлагаа дайчлах, сайн засаглалын зарчмыг анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар хөрөнгийн биржийн үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй байлгах, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс зээлийн хямд эх үүсвэрийг шийдвэрлэх, хэрэглээний зээлийг хязгаарлаж, бизнесийн орчныг дэмжихэд чиглэж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Улсын Их Хурлаас байгуулагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн ажлын хэсэгтэй хамтран ажиллах, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд шаардлагатай реформыг хийх шаардлагатай талаар үг хэлсэн болно.

9/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

10/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь
----------	--

	<p><i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.</p>
4	<p><i>/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Лувсандоржийн Сонор нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:</p> <p>1/Нэр дэвшигч Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилогдвол:</p> <p>Лувсандоржийн Сонор миний бие нь 2015 оноос одоог хүртэл Сангийн яамны Санхүүгийн бодлогын газарт төслийн зөвлөх, мэргэжилтэн, хэлтсийн дарга болон газрын даргаар ажиллаж байна. Энэ хугацаандаа Засгийн газраас банк, даатгал, бичил санхүүгийн салбарт авч хэрэгжүүлэх дунд хугацааны бодлого, стратегийг тодорхойлох, санхүүгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр тасралтгүй ажиллаж байна.</p> <p>Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой асуудал, Монгол Улсын зээлжих зэрэглэл, Засгийн газрын гадаад санхүүжилт, өрийн зохицуулалтын арга хэмжээний асуудал, болон ОУВС-гийн дэмжлэгтэй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хэлэлцээрт ажиллаж байсан туршлагатай. Тухайлбал, 2019-2020 онуудад Монгол Улс FATF-ийн саарал жагсаалтаас гарах асуудлыг ахлан хэлэлцээр хийж, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх багц хуулийг батлуулан ажилласнаар Монгол Улс саарал жагсаалтаас гарсан.</p> <p>Өрийн үйлчилгээний зардлын төсөвт үзүүлэх ачааллыг бууруулж, урт хугацаанд жигдлэх, өрийн багцын эргэн төлөгдөх дундаж хугацааг уртасгах зорилгоор Дим сам, Мазаалай, Хуралдай, Гэрэгэ, Номад, I, II, III бондууд болон</p>

Хөгжлийн банкны бондыг олон улсад амжилттай арилжаалах, Засгийн газрын 2024 онд эргэн төлөгдөх Хуралдай бонд, 2026 онд эргэн төлөгдөх Номад бондын тодорхой хэсгийг дахин санхүүжүүлэх өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд манлайлан оролцсон туршлагатай.

Монгол Улсын санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжилтэй хөл зэрэгцэж, олон улсын сайн туршлага, стандартуудыг нэвтрүүлэх зорилгоор Зүүн өмнөд Азийн орнууд болон Япон Улс, Солонгос Улс, БНХАУ хамарсан ASEAN+3-ийн “Азийн бондын зах зээлүүд санаачилга”-д гишүүн бус ажиглагчаар 2018 оны 5 сард нэгдэн орох ажлын хэсгийг ахалж ажилласан. Ийнхүү бүс нутгийн санаачилгад нэгдэн орсноор Монгол Улсаас холбогдох төлөөлөгчид “ASEAN+3 бондын зах зээлийн форум”-д оролцож, санхүүгийн салбарт бүс нутгийн хэмжээнд хийгдэж байгаа интеграцчлалд нэгдэх, сайн туршлага, олон улсын стандартыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн.

УИХ-ын 2024 оны 5 дүгээр сарын 16-ны өдрийн чуулганаар хэлэлцэн батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлыг ахалж ажилласан. Хуулийн төсөл батлагдсанаар хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, мэргэжлийн урт хугацаат хөрөнгө оруулагчдыг бий болгох, зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг сайжруулах, үнэт цаасны зах зээлийн хөгжлийг татварын орчноор дэмжих боломжийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3.9-т "Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системийн цогц шинэчлэлийг хэрэгжүүлж, олон улсын стандарт бүхий нэгдсэн шийдлийг зах зээлд нэвтрүүлнэ." гэж заасан. Энэ хүрээнд Монгол Улсын Сангийн Сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ний өдрийн 212 дугаар тушаалаар Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн системийн уялдаа холбоог хангах, цогц шинэчлэлийг эхлүүлэх талаар судалж, холбогдох санал дүгнэлтийг гарган, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ахалж, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Түүнчлэн, Сэндбоксын зөвлөлийн гишүүний хувьд Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших сэндбокс зохицуулалтын орчныг бий болгох, оролцогчид тавигдах шаардлагыг тодорхойлох чиглэлээр өөрийн санал дүгнэлтийг дэвшүүлэн, хамтран ажиллаж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-д тусгагдсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэмжээг тооцсон. Энэхүү тооцооллоор бидэнд цаашид хөгжлийн томоохон зорилтуудад хүрэх, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд их хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлага тулгарч байна. Эдгээр төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд дан ганц улсын төсвийн хөрөнгө оруулалт хангалтгүй бөгөөд

хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, нийгэм эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд олон улсын жишгийн дагуу ажиллах шаардлагатай болж байгаа билээ.

Тиймээс цаашид Засгийн газар, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид болон бусад хөгжлийн түнш байгууллагуудын зүгээс бодлого, үйл ажиллагаа, санхүүгийн эх үүсвэрээ үндэсний болон олон улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсөв санхүүгийн шинэчлэл хийх замаар хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газраас Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийн уялдааг сайжруулах зорилгоор Сангийн яам болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр хамтран “Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү “Үндэсний санхүүжилтийн нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулах, батлах ажлыг ахалж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын бодлогын зөвлөлийн гишүүний хувьд даатгалын салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах, даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох салбарын тогтвортой өсөлтийг хангах зэрэг чиглэлээр тогтмол санал дүгнэлтээ хүргүүлэн, даатгалын салбарын бодлогын уялдаа холбоог ханган ажиллаж байна.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн төслийг УИХ-д өргөн барих ажлын хэсгийн гишүүнээр ажиллан, 2025 оны 01 сарын 09-ний өдөр тус хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр уур амьсгалын өөрчлөлт, зудын гамшигт үзэгдэл нэмэгдэхийн хэрээр нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуулиар хатуу тогтоож өгсөн байгааг шинэчлэх, үргэлжлэн бий болох зудын хүнд нөхцөлийг даван туулах хүрээнд даатгуулагч малчин болон даатгалын компани хооронд байгуулсан тухайн жилийн гэрээний дүнг үндэслэн нөхөн төлбөрийн тодорхой хэмжээг нэг удаа урьдчилсан байдлаар олгох зүйл заалтыг боловсруулаад байна.

Мөн, даатгалын салбарын хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, салбарын хөгжлийг дэмжих хүрээнд даатгалын салбарт мөрдөгдөж буй гол хуулиуд болох Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай болон Жолоочийн даатгалын тухай хуулиудыг шинэчлэх ажлыг авч хэрэгжүүлж байна

Өөрийн эзэмшсэн мэдлэг, боловсрол, ажлын туршлагад үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр сонгогдсоноор санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа, баримтлах бодлогын хувьд уялдаа холбоог ханган өөрийн хувь, нэмрээ оруулан ажиллах болно.

2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Лувсандоржийн Сонорын ирүүлсэн материал болон сонголын үр

	дүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.
--	--

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Шагдаржав Нэр: Хандсүрэн Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Монголбанкны Ерөнхийлөгч
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:	
<p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.</p> <p>1/Нэр дэвшигч Шагдаржавын Хандсүрэн нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.</p> <p>2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.</p> <p>3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:</p>	

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soronznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

4/Мэдээллийн дагуу сонсголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Ш.Хандсүрэн нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс асуулт асуугаагүй болно.

8/Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар хэрэглээний зээлийн өсөлтийг хянах, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг цахимжуулж, үйл ажиллагааг хурдан шуурхай явуулахад анхаарал хандуулах талаар үг хэлсэн болно.

9/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

10/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	<p>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж томилно.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/</p>
----------	--

	<p>явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайланг гаргалаа.</p>
4	<p><i>/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Шагдаржавын Хандсүрэн нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:</p> <p>1/Нэр дэвшигч Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилогдвол:</p> <p>2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Шагдаржавын Хандсүрэнгийн ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.</p>

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГАД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	<p>Эцэг/эхийн нэр: Мягмарсүрэн Нэр: Буяндэлгэр Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо</p>
2	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга</p>
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:	
<p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон</p>	

гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/ ажиллана.", 29 дүгээр зүйлийн 29.2-т "Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.", 29.3-т "Хяналтын зөвлөлийн даргад Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Хууль зүйн Байнгын хороо тус бүр хоёр хүний нэр дэвшүүлнэ.", Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт "Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна." гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.

1/Нэр дэвшигч Мягмарсүрэнгийн Буяндэлгэр нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт"-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу "Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай" тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soronznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

-Мэдээллийн дагуу 1 оролцогч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлт хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж, баталгаажуулж, оролцуулсан болно.

4/Байнгын хорооны ажлын албанаас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.2-т заасны дагуу сонсголд оролцогчид сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч М.Буяндэлгэр нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Оролцогч Б.Ганбаяр нэр дэвшигчээс дараах асуултыг асуусан. 1) Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 3 жилийн санхүүгийн тайланг уншсан уу?

8/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Х.Ганхуяг, Л.Соронзонболд, Ж.Алдаржавхлан, П.Сайнзориг, Н.Батсүмбэрэл нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай: Хөдөө аж ахуйн салбарт туршлагатай хүний хувьд тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн эрх зүйн зохицуулалтыг анхаарах, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн зүгээс ил тод, хариуцлагатай байдалд хяналт тавих, хувьцаат компанийн санхүүгийн тайлагнал хуульд нийцсэн, үнэн зөв байх, жижиг хувьцаа эзэмшигчдэд үнэн зөв санхүүгийн тайланг хүргэхэд анхаарах шаардлагатай талаар,

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг: Нэр дэвшигчийн эзэмшсэн мэргэжил, мэргэшил, ажил эрхлэлтийн байдал нь Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргын албан тушаалын шаардлагад нийцэж байгаа эсэх, нэр дэвшигч нь Санхүүгийн зохицуулах хорооны гүйцэтгэх үйл ажиллагаа, хамрах салбар, хорооноос цаашид хэрэгжүүлэх ажлууд, мөн арилжааны банкнуудын хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалах, уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, ашигт малтмалыг биржээр дамжуулах арилжаалах үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээллийн талаар,

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Нэр дэвшигч Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргын эрх, үүрэг, ажиллах журамтай танилцсан эсэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан: Уг албан тушаалд томилогдох хүсэл зоригийн илэрхийллийн талаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХК дээр дарагдсан хувь хүмүүсийн ногдол ашгийг иргэд өөрсдөө хүсэлт гаргаж байж ногдол ашгаа авч байгааг зогсоож, хадгалагдсан ногдол ашгийг эздэд нь аливаа хүсэлтгүйгээр хуваарилахад чиглэж ажиллах талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг: Даатгалын арга механизмыг ашиглан өмчийн харилцааг хамгаалах чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулах, нэр дэвшигчийн одоо эрхэлж буй улс төрийн албан тушаалаас Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвших нь хууль зүйн хувьд боломжтой эсэх, Монгол Улсын банк, санхүүгийн салбарыг гацаанаас гаргахад хувь нэмрээ оруулах, салбар салбарын мэргэшсэн албан тушаалтнуудтай харилцах, мэтгэлцэх, хяналт тавихад нэр дэвшигчийн ур чадвар хангалттай эсэх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл: Санхүүгийн зах зээлийн харилцаа нь банк, санхүүгийн байгууллага, даатгал, цахим мөнгө гэх мэт нарийн мэргэшлийн салбарын асуудлуудыг хамрах тул нэр дэвшигч уг албан тушаалд томилогдсон тохиолдолд эргэлзээ үүсэх эсэх талаар;

9/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд нэр дэвшигч уг албан тушаалд томилогдсон тохиолдолд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж чадах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг уг албан тушаалд банк, санхүү, эдийн засгийн нарийн мэдлэг шаардагддаг тул нэр дэвшүүлэх саналаа дахин харгалзаж үзэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг санхүүгийн зах зээл нь хяналтын зөвлөлөөр дамжуулан хяналт тавьдаг салбар тул нэр дэвшүүлэх саналаа дахин харгалзан үзэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл албан тушаалын чиг үүргийн хүнд, ярвигтай, нарийн мэргэшлийн ур чадвар шаардсан тул нэр дэвшигч нэр дэвшүүлэх саналаа дахин харгалзах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай удирдах түвшний албан тушаал хаших тул бэлтгэл хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан санхүүгийн салбарт хангалттай үйл ажиллагаа эрхлээгүй тул нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй гэж үзэж, нэр дэвшигчийг саналаа эгүүлэн татах талаар үг хэлсэн болно.

10/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	<p>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/ ажиллана.”, 29 дүгээр зүйлийн 29.2-т “Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.”, 29.3-т “Хяналтын зөвлөлийн даргад Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Хууль зүйн Байнгын хороо тус бүр хоёр хүний нэр дэвшүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.</p>
4	<p><i>/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд</i></p>

харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшигч **Мягмардоржийн Буяндэлгэр** нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:

1/Нэр дэвшигч Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргаар томилогдвол:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан. Энэ хүрээнд Монгол улсын Засгийн газраас төрийн бодлого, гадаад худалдаа, дэд бүтэц, санхүү хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаагаар дэлхийн улс орнуудтай холбогдох улс үндэстэн дамнасан томоохон 14 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь үндсэн 7 бүс болон Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд бүсчилсэн байдлаар хуваарилагдаад байгаа юм. Тус төсөл хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 225 орчим төсөл, арга хэмжээ төлөвлөгдөөд байгаа ба энэхүү арга хэмжээнд дотоодын тэр ялангуяа орон нутгийн хөрөнгө оруулагчдын оролцоо, санхүүжилтийг хангах асуудлыг авч үзэх хэрэгтэй байгаа юм. Тиймээс бүс бүрт банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянах шаардлагатай байна.

Иймээс миний бие Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн орон зайн эдийн засгийн бүсчлэлийн тулгамдсан асуудал болох хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангахад тулгамдаж буй санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянах чиглэлээр хорооноос хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөн туслах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хүсэлт гаргаж байна. Энэ хүрээнд тус хуулийн 3-р зүйлд заасан “хоршооны Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан хадгаламж, зээлийн үйл ажиллагаа” болон “үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа”-г хэрэгжүүлэх асуудлыг голлон анхаарч ажиллах болно. Үүнд:

1. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эдийн засгийн анхан шатны нэгж болох суманд эдийн засгийн дэд бүтцийг шинээр бий болгох шаардлагатай байгаа юм. Сумын эдийн засгийн бүтэц нь анхан шатны хоршоо түүнд суурилсан дундын хоршоонд суурилан бий болох боломжтой. Энэхүү асуудал нь хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, санхүүгийн үйлчилгээ, бараа, түүхий эдэд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргах, арилжихтай холбогдсон хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаанаас хамаарч байна. Иймд дээр дурдсан санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хорооны үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
2. Монгол улсын хот суурин газрын хувьд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаанаас хамаарсан томоохон төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн асуудал, зуучлалын зохицуулалтаас үүдсэн хохирол их байна. Одоогоор хот суурин газрын хувьд Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь зөвхөн худалдах, худалдан авахтай холбоотой харилцаанд оролцож байна. Үл хөдлөх хөрөнгийн хамгийн онцгой хэсэг болох газрын хувьд зөвхөн цахим дуудлага худалдаагаар үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байна. Гэвч газар болон үл хөдлөх

	<p>хөрөнгө өмчлөгчид санхүүгийн үйлчилгээг бүрэн авч чадахгүйгээс шалтгаалан хөрөнгө оруулалтын боломжоо алдсаар байна. Тиймээс газар, үл хөдлөх хөрөнгийн санхүүгийн үйл ажиллагаанд чухал үүрэг бүхий “бирж”-ийн санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулах асуудал орхигдоод байна Иймд хорооны дээрх чиглэлийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.</p> <p>Миний бие бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшилд 22 жил ажилласан. Үүнээс Улаанбаатар хотын орон зайн эдийн засгийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр 12 жил, Улс, бүс нутгийн хөгжлийн чиглэлээр 5 жил, хувийн хэвшилд санхүүгийн чиглэлээр 5 жил тус тус ажилласан. Энэ хугацаанд хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангахад тулгамдаж буй гол хүчин зүйл нь томоохон төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт, тэдгээрт оролцогчдын зохицуулалт болохыг тодорхойлсон. Эдүгээ Монгол улсын хувьд хөрөнгө оруулалтын гол оролцогч нь төр байсаар байна. Энэ асуудлыг банкны үйл ажиллагаанаас гадна санхүүгийн үйлчилгээг зөв зүйтэй зохион байгуулах замаар оролцогчдын эрхийг хамгаалж, оролцоог нэмэгдүүлэн зохицуулах боломжтой юм.</p> <p>2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Мягмардоржийн Буяндэлгэрийн ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн даргад тавигдах шаардлагыг хангаагүй гэж үзлээ.</p>
--	--

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	<p>Эцэг/эхийн нэр: Оюунтөгс Нэр: Оч Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо</p>
2	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүн</p>
<p>Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/ ажиллана.”, 29 дүгээр зүйлийн 29.2-т “Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.”, 29.3-т “Хяналтын зөвлөлийн даргад Улсын Их</p>	

Хурлын Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Хууль зүйн Байнгын хороо тус бүр хоёр хүний нэр дэвшүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.

1/Нэр дэвшигч Оюунтөгсийн Оч нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soronznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

-Мэдээллийн дагуу 1 оролцогч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлт хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж, баталгаажуулж, оролцуулсан болно.

4/Байнгын хорооны ажлын албанаас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.2-т заасны дагуу сонсголд оролцогчид сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч О.Оч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Оролцогч Б.Ганбаяр нэр дэвшигчээс дараах асуултыг асуусан. 1) Клиринг болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд байршиж буй иргэдийн хувьцаа авсан, зарсан мөнгө 2 хоног байршиж хүүгийн орлого олж байгаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд саад болж байна гэж та үздэг үү?

8/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалд өгөх үнэлэлт, дүгнэлт, цаашид ямар үйл ажиллагаа хэрэгжүүлбэл зохих тухай нэр дэвшигчийн төлөвлөгөө, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ямар арга хэмжээ авах санал дэвшүүлж байгаа болон уг салбар нь зөвхөн санхүү, эдийн засгаас гадна арилжааны банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүдийн зохицуулалт гэх мэт хууль, эрх зүйн мэдлэг ур чадвар шаардсан салбар байдаг тул үүнд анхаарал хандуулах шаардлагатай талаар асуулт асууж, хариулт авсан.

9/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Нэр дэвшигч уг албан тушаалд томилогдсон тохиолдолд зөвхөн үнэт цаасны зах зээлээс гадна, даатгалын, хөрөнгийн, үл хөдлөх, виртуаль хөрөнгийн зах зээлд анхаарал хандуулж, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны явц дахь хүнд суртлыг арилгахад анхаарч ажиллах талаар үг хэллээ.

10/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

11/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	<p>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/ ажиллана.”, 29 дүгээр зүйлийн 29.2-т “Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.”, 29.3-т “Хяналтын зөвлөлийн даргад Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Хууль зүйн Байнгын хороо тус бүр хоёр хүний нэр дэвшүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p>
----------	---

	<p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.</p>
<p>4</p>	<p><i>/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./</i></p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Оюунтөгсийн Оч нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:</p> <p>1/Нэр дэвшигч Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилогдвол: Хяналтын зөвлөлийн гишүүний хувьд санхүүгийн зах зээлийн эрүүл, аюулгүй, хурдтай хөгжилд хөтлөх эрх зүйн болон зохицуулалтын үйл ажиллагааны санал, санаачлагад дэмжлэг болж ажиллах зорилго тавина. Хорооны зохицуулалтын үйл ажиллагаа нь нээлттэй, хялбар байхад анхаарч ажиллана. Үүнд:</p> <p>Хорооны шийдвэртэй холбоотой гомдол, саналын шийдвэрлэлт: Хороонд гаргасан аливаа гомдол, санал нь санхүүгийн зах зээлд оролцогчдын нийтлэг эрх ашигт нийцтэй гарч чадаж байгаа эсэхэд үнэлэлт өгдөг байх.</p> <p>Зохицуулалттай этгээдийн тайлагнал: Үнэт цаас гаргач, зохицуулалттай этгээд нь хөрөнгө оруулагч, зохицуулагчид бүрэн мэдээллийг цаг тухайд нь гаргадаг байх, хялбар бөгөөд үр дүнтэй арга замуудыг нэвтрүүлэхэд дэмжлэг болох, түүний стандарт хэмжүүртэй болгох.</p> <p>Зах зээлд оролцогчдын хүртээмжийг нэмэгдүүлэх: Үнэт цаасны зах зээлд оролцогчдын хүртээмжийг нэмэгдүүлэх, жижиг хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Хорооноос баримтлах зохицуулалтын арга хэмжээг санаачлах, санал санаачлагыг дэмжиж ажиллана.</p> <p>Хүний нөөцийн чадавхжуулалт: Хороо болон зах зээлд ажиллаж буй хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр өөрийн болон албан шугамаарх холбоо, хүрээллээ ашиглан гадаадын зохицуулагч байгууллага, сургалтын байгууллагуудтай хамтран ажиллана.</p> <p>Шинэ хэрэгслүүд: Хороо нь зохицуулагчаас гадна, Монголын Санхүүгийн зах зээлийн хөгжлийг тодорхойлох байгууллагын хувьд миний бие Хяналтын зөвлөлийн гишүүний хувьд Даатгалын салбарыг улам хөгжүүлэх, Үл хөдлөх хөрөнгө оруулалтын хүртээмжийг ил тод, нээлттэйгээр нэмэгдүүлэх, ББСБ зах зээлийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, Уламжлалт болон шинэ хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн зохицуулалтын орчныг сайжруулах, гэхмэт санаачлагуудыг Ажлын албатай хамтран боловсруулах болно.</p> <p>Мэдээлэл, тайлагнал: Улсын Их Хуралд хүргүүлэх Хороо болон Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг сайжруулах, цаашдын зохицуулалт, хөгжлийн санал, шийдэл боловсруулж ажиллана.</p>

	2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Оюунтөгсийн Очийн ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.
--	--

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Болдбаатар Нэр: Энхбаяр Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал
	Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:	
<p>Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “Хяналтын зөвлөл” гэх/ ажиллана.”, 29 дүгээр зүйлийн 29.2-т “Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.”, 29.3-т “Хяналтын зөвлөлийн даргад Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Хууль зүйн Байнгын хороо тус бүр хоёр хүний нэр дэвшүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.</p> <p>1/Нэр дэвшигч Болдбаатарын Энхбаяр нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.</p> <p>2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний</p>	

өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, sogonnews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

-Мэдээллийн дагуу 1 оролцогч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлт хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж, баталгаажуулж, оролцуулсан болно.

4/Байнгын хорооны ажлын албанаас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.2-т заасны дагуу сонсголд оролцогчид сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Б.Энхбаяр нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Оролцогч Б.Ганбаяр нэр дэвшигчээс дараах асуултыг асуусан.

1. Клиринг болон Үнэт цаасны төвлөрөн хадгаламжийн төвийн дансанд байршиж буй иргэдийн хувьцаа авсан, зарсан мөнгө 2 хоног байршиж хүүгийн орлого олж байгаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд саад болж байна гэж та үздэг үү?
2. Бонд гаргахад үнэлгээ хийлгэж нийтэд ил тод зарлах ёстой боловч холбогдох журмын дагуу үнэлгээ хийлгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн. Уг журмын эсхүл гэдэг үгийг авч хаяж өөрчлөлт хийж чадах уу?
3. Хувьцаат компани хэлбэрээ өөрчилж, хаалттай компани болж байгаа нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироосоор ирсэн. Богд банк. Монгол Улсын хуулиар хориглоогүй ч бусад улсад мөнгө угаах, санхүүгийн луйвар гэж үздэг. Эрх зүйн орчны өөрчлөлт хийх зориг байна уу?
- 4.СЗХ-ны ТУЗ-ийн шийдвэрийг тухайн шийдвэр гарсан өдөр нь хөрөнгийн бирж дээр байршуулдаг болгох талаар журамд өөрчлөлт хийх үү?
5. Компанийн тухай хуулийн 1%-ийн хувьцаа эзэмшигч шүүхэд нэхэмжлэх гаргах эрхийг хаадаг заалтыг хүчингүй болгох талаар таны бодол?
- 6.Үнэт цаас өвлүүлэх8 бэлэглэх журамд заагдсан үйлчилгээний хөлсийг үнийн дүнгээс авах нь зөв үү? Ер нь ингэж нэр шилжүүлэхэд шимтгэл авч байгаа талаар таны бодол?

8/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Р.Сэддорж нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Санхүүгийн зах зээлийн аль чиглэлд нэн тэргүүнд анхаарч ажиллах хүсэлтэй байгаа, жижиг, дунд бизнес эрхлэгчид ялангуяа орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдэд хувьцаа, бонд гаргахад нь ямар байдлаар дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзэж байгаа талаар;

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж: Орон нутаг дахь аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж буй эдийн засгийн дарамт шахалтыг хэрхэн бууруулах боломжтой талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

9/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, даатгалын зах зээл гэх мэт хөрөнгийн зах зээлийн бусад салбаруудад анхаарч ажиллах талаар үг хэлэв.

10/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

11/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3 Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь
/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “Хяналтын зөвлөл” гэх/ ажиллана.”, 29 дүгээр зүйлийн 29.2-т “Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.”, 29.3-т “Хяналтын зөвлөлийн даргад Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Хууль зүйн Байнгын хороо тус бүр хоёр хүний нэр дэвшүүлнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

4

/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч **Болдбаатарын Энхбаяр** нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:

1/Нэр дэвшигч Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилогдвол:

Миний бие Б.Энхбаяр нь Монгол улсын анхны карт гаргагч Голомт банкинд ажиллаж байх хугацаандаа Монгол улсад төлбөрийн картыг нэвтрүүлэх, хэрэглээг бий болгох, харилцагчдад таниулах сурталчилах, төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх ажлыг төслийн багийн хамт амжилттай зохион байгуулсан ба ажиллах хугацаандаа өөр бусад олон дэвшилтэт үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг гардан зохион байгуулсан. Мөн бизнесийн салбарт ажиллах хугацаандаа банк бус санхүүгийн байгууллага, гадаадын банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр ажилласан туршлагатай болно.

Би өөрийн Монгол улсын хөрөнгийн зах зээл, санхүүгийн болон бизнесийн салбарт ажиллаж хуримтлуулсан туршлага, эзэмшиж мэргэшсэн мэргэжил, мэдлэг чадварыг бүрэн дайчлан ажиллах ба тус байгууллагын ирээдүйн зорилго болон өөрийн дотоод итгэл үнэмшил, үнэт зүйлийг эрхэмлэн чин шударгаар ажиллаж чадна гэдгээ үүгээр илэрхийлж байна.

Хийхээр төлөвлөж буй ажил:

Хөрөнгийн зах бол мэргэжлийн салбар. Эдийн засгийн хөгжлийг хурдасгах гол салбаруудын нэг. Ялангуяа Монгол Улсын ЗГ-аас томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг урьж оролцуулах, мөн ТӨХК-иудыг биржээр дамжуулж хувьчлах, Монгол улсын иргэн бүр хувьцаа эзэмшиж эхэлж байгаа маш чухал цаг үе байгаа одоо. Монгол улсад харьцангуй эрх зүйн орчин сайн бүрдсэн, зохицуулагдсан гэж хардаг. Хэрвээ томилогдвол:

1. Хөрөнгийн зах зээлийн талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, мөн одоо зохицуулалттай үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд анхаарч, хянаж ажиллахыг зорино. Ялангуяа Хувьцаат компаниудын тайлан цаг хугацаандаа гардаг байх, үнэн зөв байх, арилжаа нь эргэлзээгүй байх, хувьцаа эзэмшигчид, тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдсан байх тал дээр илүүтэй анхаарч ажиллана.
2. Хөрөнгийн зах зээлд оролцогч иргэд, ААН-үүд, гадаадын хөрөнгө оруулагчдад шинэ боломжууд, арга хэрэгслүүдийг бий болгох тал дээр санал санаачлагатай ажиллаж, СЗХорооны удирдлагууд болон салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдтэйгээ хамтарч, дэмжиж ажиллана.
3. Сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж, тэлж байгаа ББСБ-уудаас олгож байгаа Application-ний зээл гэж нэрлэгддэг зээлийн үйлчилгээнд зохицуулалт, хяналт маш чухал байгаа. Иргэд олон давхар зээл авах

	<p>боломжтой байгаа нь урт хугацаандаа зээлийн эргэн төлөлтөд эрсдэл учирч, улмаар банк, санхүүгийн салбарт ч сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдал үүсэх эрсдэл бодитой байгаа.</p> <p>4. Хувийн хөрөнгө оруулалтын сангууд, тэр дундаа Хувийн тэтгэврийн сан болон Эрүүл мэндийн даатгалын сангуудыг хөгжүүлэх нь чухал байгаа. Тиймээс энэ тал дээр илүүтэй анхаарч, санал санаачлагтай ажиллахыг зорьж байгаа.</p> <p>2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Болдбаатарын Энхбаярын ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.</p>
--	--

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	<p>Эцэг/эхийн нэр: Намсрай Нэр: Батнасан Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо</p>
2	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн</p>
<p>Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:</p> <p>Төв банк/Монголбанк/-ны тухай тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.</p> <p>1/Нэр дэвшигч Намсрайн Батнасан нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.</p>	

2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

--Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soronznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

4/Мэдээллийн дагуу сонсголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Н.Батнасан нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Сайнзориг, Х.Ганхуяг нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Монголбанкны Мөнгөний бодлого, Төсвийн бодлого хоёр нэг чиглэлд байсан бол ямар нөхцөл байдалтай байх, зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар судалгаа хийсэн эсэх, Мөнгөний бодлогын үйл ажиллагаанд холбогдуулан ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа, хүүгийн татаасаар жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжээгүй бол Монгол Улсын эдийн засагт ямар нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа талаар;

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг: Зээлийн хүүг бууруулахад чиглэсэн ямар арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байгаа,

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг: Бодлогын хүүг зохистой түвшинд байгаа гэж үзэж байгаа эсэх, зээлийн хүү, иргэдийн харилцах дансны хүүгээс татвар авч байгаа нь олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаа эсэх, төсвийн бодлого, мөнгөний бодлогын уялдааны талаарх нэр дэвшигчийн илэрхийлсэн байр суурь, өнөөдрийн банкны салбарын өрсөлдөх орчинд өгөх үнэлэлт, цаашид авах арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авлаа.

8/ Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл төсөв, мөнгөний бодлогын уялдаа, банкны салбарт шударга өрсөлдөөнийг бий болгох, Монголбанкны хараат бус, бие даасан байдлыг хангахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл цаг тухайдаа, үнэн бодитой гардаг байхад анхаарах, Монголбанкны тоон валют гаргах асуудлаар судалгаа хийх, жижиглэнгийн тоон валют гаргах асуудлыг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар зээлийн хүү өсөх үндсэн шалтгаан болон инфляцыг бууруулахад чиглэж ажиллах, гадаад улсын банк Монгол Улсад орж ирэхгүй байгаагийн гол шалтгаан болох ханшийг эрсдэлийг бууруулахад чиглэсэн тогтолцоо муу байгаа талаар, актив удирдлагын үйл ажиллагааны компани шаардлагатай болон зээлийн мэдээллийн санг Монголбанк өөр дээрээ байлгаж, зээлийн хүүгийн аргачлалаа тодорхойлох нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

9/ Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

10/ Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	<p>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Төв банк/Монголбанк/-ны тухай тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.</p>
4	<p><i>/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./</i></p>

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч **Намсрайн Батнасан** нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:

1/Нэр дэвшигч Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилогдвол:

Сүүлийн жилүүдийн нөхцөл байдлаас үзэхэд Төв банкнаас явуулж буй мөнгөний хатуу бодлого, ЗГ-ын төсвийн хэт тэлэлт хоёр нь мөнгөний болон сангийн бодлогын хооронд уялдаа холбоо сул байгааг харуулж байгаа юм. Энэ нь цаашдаа инфляци, зардлын өсөлт, зээлийн хүү зэргээр дамжин өрсөлдөх чадварыг бууруулах, макро эдийн засгийн нөхцөл байдлыг тогтворгүйжүүлэх эрсдэлтэй байна.

Хөгжлийн банк болон Төрийн банк зэрэг төрийн өмчийн оролцоотой банкууд дотоодын аж ахуйн нэгжүүдэд ДХБ-ын дүрэм журмаар хориглосон татаас, дэмжлэг үзүүлж байгаа нь цаашид энэ байгууллагын гишүүн орнуудаас манай улсын эсрэг хариу арга хэмжээ авах нөхцөл байдалд оруулах эрсдэлтэй байгаа тул хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулахын төлөө ажиллана.

Дижиталчлал, хиймэл оюун зэрэг нь дэлхий нийтийн хэмжээнд банкны салбарын зардал болон эрсдлийг бууруулах гол арга хэрэгсэл болох шинжтэй байна. Үүнтэй холбоотойгоор банкны салбарт дижитал шийдлүүдийг нэвтрүүлэх, хиймэл оюунд суурилсан эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх, шаардлагатай дүрэм журам, зохиуулалтыг бий болгох шаардлагатай.

Бодлогын хүү нь арилжааны банкнуудын хадгаламж, зээлийн хүү, тэдгээрээр дамжин банкны салбар дах мөнгөний нийлүүлэлтэд хүчтэй нөлөөлдөг. Иймд бодлогын хүүг шинжлэх ухааны арга аргачлалд тулгуурлан оновчтой тогтоох асуудал чухал. Нөгөө талаас мөнгөний нийлүүлэлт, түүний дотор эмиссийг оновчтой хэмжээний талаарх тооцоололд суурилан хэрэгжүүлэх нь чухал.

Иймд цаашид Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр сонгогдсон нөхцөлд:

- Мөнгөний бодлого, сангийн бодлогын уялдааг сайжруулах;
- Банкны салбарын хууль тогтоомж, дүрэм журмуудыг олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нийцүүлэх;
- Банкны салбарын зардал ба эрсдлийг бууруулах тал дээр ажиллах;
- Бодлогын хүү болон мөнгөний нийлүүлэлтийн хэмжээг оновчтой тогтоох зэрэг асуудлуудад төвлөрч ажиллах болно.

2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Намсрайн Батнасангийн ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан

ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Раднаасэд Нэр: Даваадорж Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:	
<p>Төв банк/Монголбанк/-ны тухай тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.</p> <p>1/Нэр дэвшигч Раднаасэдийн Даваадорж нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.</p> <p>2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.</p> <p>3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:</p> <p>-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.</p> <p>--Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soronznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.</p>	

4/Мэдээллийн дагуу сонголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Р.Даваадорж нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Л.Соронзонболд, П.Сайнзориг, Э.Батшугар, Дав.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг: Зээлийн хүүг бууруулахад ямар арга хэмжээ авах, бодлогын хүүг ямар арга замаар бууруулах, банкны салбар дахь өрсөлдөөнийг хэрхэн дэмжих боломж болон төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдаа, нэр дэвшигч нь улс төрийн албан тушаал хашиж байгаа тул Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилогдсон тохиолдолд хараат бусаар, зарчмын байр суурийг хамгаалан ажиллах эсэх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Мөнгөний бодлогыг хадгалах онц шийдэл гэдгээр юуг илэрхийлсэн, өмнөх мөнгөний бодлогын аль хэрэгсэл нь байгаа оносон гэж үзэж байгаа, зээлийн хүүг бууруулахад Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа талаар;

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг: Нэр дэвшигч өөрийн нэр дэвших тухай хүсэлтдээ төсөв, мөнгөний бодлогын тэнцвэртэй нэгдсэн бодлого байхгүй талаар болон төрийн хариуцлагын механизмыг сэргээхээр дурдсан нь ямар нэгдсэн бодлого болон механизмыг илэрхийлсэн талаар, төсвийн тэлэлтийн аль хэсгийг, ямар байдлаар танах шаардлагатай гэж үзэж байгаа, зээлийн хүүг цаашид уламжлалт аргаар хуульчлан тогтоох, малчны зээлийг тэглэх асуудлаар баримтлах нэр дэвшигчийн байр суурь, нэр дэвшигч улс төрөөс ангид байж, Монголбанкны мөнгөний бодлогыг зарчмын хувьд хамгаалж ажиллаж чадах эсэх талаар;

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар: Монголбанкны үндсэн зорилго, бодлогын хүү, инфляц өндөр байгаа шалтгаан нөхцөл, Мөнгөний бодлогын хорооны цар хүрээн дэх эдийн засгийн арга хэрэгслүүд, зориулалтын бус зээлийн хэрэглээний талаарх нэр дэвшигчийн байр суурь, зээлийг зориулалтын бусаар хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, нэр дэвшигч үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдал гэдгээр юуг илэрхийлсэн талаар;

Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар: Монгол Улсад төгрөгийн үнэ цэн унаж байгаатай холбогдуулан цаашид авахаар төлөвлөсөн арга хэмжээ, Монголбанкны үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомжийг шинэчлэх хүрээнд ямар ажил хийхээр төлөвлөж байгаа талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан: Нэр дэвшигч судалгааны ажлуудаа гүйцэтгэхдээ гадаадын ямар хэл дээрх эх сурвалжийг ашигладаг, Монголбанкны одоогийн статусыг хэрхэн тодорхойлж байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

8/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг улс төрөөт хараат бус, ангид байж, зарчим баримталж ажиллах, Банкны тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нэр дэвшигч албан тушаалд тавигдах зарчим, ёс зүйг баримтлан ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан төсвийн тэлэлттэй өнөөгийн цаг үед Монголбанкнаас бусад байгууллагатай харилцах харилцаа сул байдаг тул Мөнгөний бодлогын хорооны үйл ажиллагаа чухал ач холбогдолтой талаар үг хэлсэн болно.

9/Сонголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

10/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3 **Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь**
/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/

Төв банк/Монголбанк/-ны тухай тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

4 */Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./*

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч **Раднаасэдийн Даваадорж** нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:

1/Нэр дэвшигч Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилогдвол:

Засгийн газар болон Төв банкны хоорондох төсөв, мөнгөний бодлогын уялдаа алдагдаж, тэнцвэртэй нэгдсэн зохицуулалт дутагдаж байгаа нь үнэ өсөх, монгол төгрөгийн ханш сулрах, нийгэмд ядуурал нэмэгдэх, аж ахуй нэгжүүд олноор хаалгаа барих гол шалтгаан нь болжээ. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларч, мөнгөний нийлүүлэлт эрс нэмэгдэж, улмаар макро эдийн засгийн тогтвортой байдал эрсдэл дагуулах хэмжээнд байна. Монгол Улсын хувьд эдийн засгаа тогтвортой хөгжүүлэх, иргэдэд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох, зээлийн хүүг бууруулах зэрэг асуудал өнөөдөр ч хурцаар тавигдаж байна.

Энэ бүхэн өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн Мөнгөний бодлого байгаа огт оноогүйн тод жишээ юм. Засгийн газар болон Төв банкны хоорондох төсөв, мөнгөний бодлогын уялдаа алдагдаж, тэнцвэртэй нэгдсэн зохицуулалт дутагдаж, арга барилаа эрс шинэчлэх, үгүй болсон төрийн хариуцлагын механизмыг энэ чухал салбарт сэргээх зэрэг улс орны эдийн засгийн амьдралд онц чухал шаардлагатай шийдлүүд хүлээгдэж байна.

2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Раднаасэдийн Даваадоржийн ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга

1 **Эцэг/эхийн нэр:** Батбаатар
Нэр: Мөнхзаяа
Хүйс: Эмэгтэй
Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо

2 **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**
Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн

Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:

Төв банк/Монголбанк/-ны тухай тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.”, Монгол Улсын Их

Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.

1/Нэр дэвшигч Батбаатарын Мөнхзаяа нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.

3/Сонголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

--Сонголын тов, хугацаа, сонголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soronznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

4/Мэдээллийн дагуу сонголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Б.Мөнхзаяа нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Х.Ганхуяг нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Нэр дэвшигч өөрийн боловсруулсан “Зээлийн хүүг бууруулах стратеги боловсруулах” сэдэвт илтгэлд дурдсанаас одоогийн мөнгөний бодлого ямар зөрүүтэй байгаа, одоогийн ипотекийн санхүүжилтийн үйл ажиллагааг хэрхэн өөрчлөх, Монголбанкаас тоон валют гаргахад ямар бодлого баримтлах нь зүйтэй гэж үзэж байгаа талаар,

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг: Нэр дэвшигч цаашид өөрийн зарчим, байр суурийг хамгаалж ажиллах эсэх, макро эдийн засгийг тогтвортой байлгахад эдийн засгийн аль салбарт анхаарал хандуулах, хөрөнгө оруулалт хийх ёстой гэж үзэж байгаа талаар;

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл: Монголбанкийг хэр бие даасан, хараат бус байдалтай үйл ажиллагаа явуулж байгаа талаар, үнэ тогтворжуулах хөтөлбөр болон төсвийн шинжтэй бодлогуудыг Засгийн газрын өмнөөс Монголбанк хэрэгжүүлэх нөхцөл үүсдэг талаар;

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан: Эдийн засгийн бодлогыг байгаль орчны бодлогуудтай уялдуулах талаар асуулт асууж, хариулт авлаа.

8/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг академик мэдлэгээ албан тушаал хашигдаа ашиглаж, хариуцлагатай ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд ипотекийн хүүгийн татаас нь хөрөнгийн үнийг өсгөхөд нөлөөлж байгаа болон тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд зээл олголт хэрхэн нөлөөлж байгаа асуудлаар судалгаа хийх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг улс төр, Засгийн газраас хараат бусаар ажиллах, Банкны тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг эзэмшсэн боловсрол, судалгааны ажил зэргийг харгалзаж нэр дэвшигчийг ажил хэрэгчээр ажиллаж, төлөлөсөн ажлуудаа бодитой ажил хэрэг болгох талаар үг хэлсэн болно.

9/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн болон бусад оролцогчдоос үг хэлэх санал гаргаагүй болно.

10/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	<p>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Төв банк/Монголбанк/-ны тухай тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025</p>
----------	---

	<p>оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонголт явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайланг гаргалаа.</p>
4	<p><i>/Байнгын хороо цуелуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./</i></p> <p>Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Батбаатарын Мөнхзаяа нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:</p> <p>1/Нэр дэвшигч Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилогдвол:</p> <p>Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн орон тооны бус гишүүнээр нэр дэвших үндэслэл:</p> <p>Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг тогтвортой хангаж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд мөнгөний бодлогын оновчтой шийдвэр, үр дүнтэй хэрэгжилт чухал үүрэгтэй. Би энэхүү албан тушаалд нэр дэвшихдээ өөрийн мэдлэг, ур чадвар, туршлагаа Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулахад зориулна гэсэн чин хүсэл эрмэлзэлтэй байна.</p> <p>Эдийн засгийн бодлогын туршлага</p> <p>Миний бие Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын ипотекийн корпорацитай хамтран эдийн засгийн бодлогын чиглэлээр хамтарсан судалгааны ажлууд хийж байсан туршлагатай, мөн 2022 онд Төв банкны хараат бус байдлын чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийн, төв банкнаас зохион байгуулсан</p> <p>хуралд судалгааны ажлаа танилцуулж байсан. 2013 онд докторын судалгааны ажил хийхээ хямралын үед банкны салбарын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчмуудыг судалж байсан ба эдийн засгийн мөчлөгийг түрүүлэгч индикаторуудын тусламжтай тодорхойлох арга зүйг боловсруулж байсан. 2014 онд Монгол банкны 90 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд энэ сэдвээр оролцож дэд байрын шагнал хүртэж байсан. Нийт 19 жилийн хугацаанд дээд боловсролын байгууллагад ажиллахдаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тасралтгүй хийж, Монгол Улсын эдийн засгийн онцлогийг гүнзгий ойлгодог бөгөөд гадаад, дотоод зах зээлийн өөрчлөлт, нөлөөллийг бодлогоор зохицуулах арга барилд тасралтгүй суралцаж, түүнийгээ сургалт, судалгааны ажилдаа ашиглаж байна. Ингэснээр бодлогын шийдвэр гаргах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад бодитой хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна..</p> <p>Мэдлэг, боловсрол</p> <p>Миний бие банк санхүүгийн бакалаврын зэргийг 2005 онд эзэмшсэн ба 2013 онд докторын зэрэг хамгаалсан. Олон улсад банк санхүүгийн салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг туршлагыг судлах зорилгоор дэлхийн топ 100</p>

сургуулийн нэг Австрали улсын Монашын их сургууль дахин банк, санхүүгийн мастерын зэрэг эзэмшсэн. Би санхүү, эдийн засгийн чиглэлээр сургалт судалгааны ажил хийхээс гадна судалгааны төсөлд оролцож, дүн шинжилгээ хийх, зөвлөмж боловсруулах чадвараа нэмэгдүүлж байна.

Шударга ёс, ёс зүйн баримтлал

Монгол Улсын иргэний хувьд шударга ёсыг дээдлэх, аливаа ажлыг ёс зүйтэй, хариуцлагатайгаар гүйцэтгэхийг үргэлж эрхэмлэж ирсэн. Мөнгөний бодлогын шийдвэрүүд нь олон нийтийн итгэл хүлээсэн байх ёстой бөгөөд энэ чиглэлд миний ёс зүйн өндөр үнэлэмж хэрэгтэй гэж үзэж байна. Мөн Австрали улсад суралцаад төгсөж ирээд Дэлхийн ёс зүйн өдөр, Тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжих төслийн уралдаан, сайн удын үзэсгэлэнг жил бүр тэмдэглэн өнгөрүүлэх санаачилга гарган бүх их дээд сургуулийн оюутнуудад мэдлэг, ойлголт өгөх ажлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. 2024 оны 10 сард болсон Ёс зүйтэй шийдвэр гаргалт сэдэвт хэлэлцүүлэгт Монголбанкны төлөөллийг урьж оролцуулсан.

Судалгааны чадвар ба дата дүн шинжилгээ

Мөнгөний бодлогын оновчтой шийдвэр гаргахын тулд зах зээлийн өөрчлөлт, гадаад, дотоодын макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх шаардлагатай. Энэ чиглэлд миний эзэмшсэн арга зүй, судалгааны ур чадвар өндөр үр дүн авчирна гэдэгт итгэлтэй байна.

Томилогдвол хийх ажлын төлөвлөгөө

- Мөнгөний бодлогын шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргах, үндэсний онцлогт тохируулан хэрэгжүүлэхэд оролцох.
- Инфляцын түвшинг тогтворжуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын шийдвэрт анхаарал хандуулах.
- Дотоодын эдийн засгийн болон олон улсын санхүүгийн орчны өөрчлөлтийг оновчтой үнэлж, цаг алдалгүй зохицуулалт хийхэд дэмжлэг үзүүлэх.
- Олон нийтийн оролцоог дэмжсэн ил тод бодлогыг хэрэгжүүлэх, эдийн засгийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, мэдээллийн ажлуудыг өрнүүлэх.
- Эдийн засгийн бодлогыг байгаль орчны тогтвортой хөгжил, нийгмийн сайн сайхныг хангах чиглэлд уялдуулах.

Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн орон тооны бус гишүүнээр томилогдвол миний мэдлэг, туршлага, ёс зүй нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, иргэдийн итгэлийг хүлээсэн мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл явцад хувь нэмэр оруулахад анхаарч ажиллах болно.

2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Батбаатарын Мөнхзаяагийн ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн

хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Бямбажав Нэр: Энх-Амгалан Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал
	Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:	
<p>Төв банк/Монголбанк/-ны тухай тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.</p> <p>1/Нэр дэвшигч Бямбажавын Энх-Амгалан нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.</p> <p>2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.</p> <p>3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:</p> <p>-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.</p> <p>Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soroiznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.</p> <p>4/Мэдээллийн дагуу сонсголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.</p>	

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Б.Энх-Амгалан нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг: Нэр дэвшигч мөнгөний бодлогын хэрэгслээр хүүг тогтоох, банкны заавал байх нөөцийн зохистой харьцааг тогтоох гэдгээр тус тус ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зорьж байгаа, инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах төлөвлөгөөний талаар;

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Одоогийн төгрөгийн ханшийг тогтворжуулахад анхаарвал зохих зүйлс, Монгол Улс дахь банкны системийн талаарх бодол, цаашид нэр дэвшигчийн баримтлах байр суурийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

8/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг ипотекийн зээлийн хүүг бодлогын хүүтэй уялдуулахыг анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан бизнес эрхлэгчдийг дэмжих, анхдагч зээл авч байгаа иргэдтэй харилцан ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж зээлийн хүүг бууруулахад анхаарч ажиллах талаар үг хэлсэн болно.

9/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

10/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i>
	Төв банк/Монголбанк/-ны тухай тухай хуулийн 27 ³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их

	<p>Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна." гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны "Их засаг" танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонголт явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайланг гаргалаа.</p>
4	<p><i>/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн санхүү, эдийн засгийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж, нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./</i></p> <p>Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч Бямбажавын Энх-Амгалан нэр дэвших хүсэлт ирүүлсэн бөгөөд:</p> <p>1/Нэр дэвшигч Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр томилогдвол:</p> <p>Эдийн засгийн нөхцөл байдал Ковид-19 цар тахал гарснаар өмнөх үетэй харьцуулахад ихээхэн өөрчлөгдөж, эдийн засгийн хүндрэл үүссэнтэй холбоотойгоор Монголбанкнаас бизнес эрхлэгчдийг дэмжих, эдийн засгийг хүндрэлийг хохирол багатайгаар даван туулах тулд бодлогын хүүг бууруулах бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Гэсэн хэдий ч дэлхий дахинд хүнс, эрчим хүч, тээвэр, шатах тослох материалын үнийн өсөлт явагдсантай холбоотойгоор инфляцыг ихээр нэмэгдүүлэх болсон нь буцаад мөнгөний бодлогоо чангатгахад хүргэсэн. Энэ бодлогын нөлөө болон гадаад эдийн засгийн сэргэлтийн үр дүнд 2023 он гарсаар инфляцын саарсан нь 2024 оноос бодлогын хүүг бууруулах боломжийг олгосон. Монгол улсын экспортын орлого 2023, 2024 онуудад огцом нэмэгдсэнээр төсөв тэлж зарлага нэмэгдсэн нь бодлогын хүүг нэмж бууруулахгүй байгаа түвшинд хадгалах шийдвэрт хүргэж байна.</p> <p>Мөнгөний бодлогын хорооны гишүүн нь үнийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлт, санхүүгийн тогтвортой байдал зэрэг эдийн засгийн үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн мөнгөний бодлогыг боловсруулахад чухал үүрэгтэй оролцдог. Энэ утгаараа миний зүгээс Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр ажиллах тохиолдолд дараах 5 чиглэлд анхаарлаа хандуулан ажиллах болно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Эдийн засгийн нөхцөл байдал, чиг хандлагад дүн шинжилгээ хийх <ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох инфляцийн түвшин, ДНБ-ий өсөлт, ажил эрхлэлт, хэрэглээний зардал, төлбөрийн тэнцэл, валютын ханшийг судлах • Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын зах зээл дотоодын эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг судлах

2. Бодлогын шийдвэр гаргахад хувь нэмэр оруулах. /Төв банкны тухай хуулийн 27.3.4-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ/
 - Төрийн мөнгөний бодлогын төсөл
 - Мөнгөний бодлогын хэрэгслийн хүүг тогтоох
 - Банкны заавал байлгах нөөцийн хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хувь, хэмжээг тогтоох
3. Бие даасан байдалд үндэслэн шийдвэр гаргана
 - Судалгаанд суурилсан шийдвэр гаргах
 - Нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргах
 - Улс төрийн болон гаднын нөлөөллөөс зайлсхийх
 - Эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэх
4. Ил тод нээлттэй байх
 - Эдийн засгийн онол, эдийн засгийн нөхцөл байдал, урьдчилсан таамаглалтай уялдуулан гаргасан шийдвэрийн үндэслэлээ олон нийтэд ил тод байдлаар танилцуулах
 - Төрийн мөнгөний бодлогын талаар холбогдох талуудтай нээлттэй харилцаж ухуулан таниулах, ойлгуулах
5. Эдийн засгийн зорилтуудыг өргөн хүрээнд авч үзэх
 - Инфляцыг зорилтот түвшинд барихын төлөө ажиллах үнийн тогтвортой байдлыг дэмжинэ.
 - Мөнгөний бодлогоор дамжуулан эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах
 - Санхүүгийн салбар дахь системд хяналт тавьж, эрсдэл үүсгэхгүй байхад анхаарч, урьдчилан сэргийлэхэд анхаарах

Мөнгөний бодлогын хорооны гишүүнээр ажиллах нь улс орны эдийн засгийн чиг хандлагыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд ажиллах үндэслэлээ дараах байдлаар тодорхойлсон.

Эдийн засгийн тогтвортой байдалд нөлөө үзүүлэх: Инфляцийг зорилтот түвшинд байлгах замаар үнийн тогтвортой байдлыг тогтоох; эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих; банкны систем болон санхүүгийн зах зээлийг системийн эрсдэлээс хамгаалах шийдвэр гаргахад хувь нэмрээ оруулах.

Эдийн засгийн гол гол зорилтуудыг шийдвэрлэх: Эдийн засгийн хямралыг (дэлхийн эдийн засгийн хямрал, түүхий эдийн үнийн хэлбэлзэл гэх мэт) мөнгөний арга хэрэгслийг ашиглан шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах; үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах замаар хэт хэлбэлзлийн эсрэг тогтворжуулах бодлого гаргах, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх.

Төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх: инфляцыг хянах замаар бага орлоготой иргэдийг хамгаалах, аж ахуйн нэгж болон айл өрхүүдэд олгох зээлийн ашигтай нөхцөлийг бий болгох; мөнгөний бодлогын талаар шийдвэр гаргахдаа жижиг бизнес эрхлэгчээс томоохон үйлдвэр хүртэлх бүх салбарын харгалзан үзнэ.

	<p>Өөрийн сурсан мэдсэн мэдлэгээ ашиглах: Одоог хүртэлх сурсан мэдсэн болон хийж ирсэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээ бодит сорилтуудыг шийдвэрлэхэд ашиглах, өөрийн болон бусад судлаачдын судалгааны үр дүнг ашиглан мөн судлаачидтай хамтран ажиллах замаар зөв шийдвэр гаргах.</p> <p>Эдийн засгийн нөөц бололцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх: хүн ам зүйн чиг хандлага, нөөцийн байдал, тэдгээрийн хоорондын хамаарал зэрэгтэй уялдсан бодлого боловсруулах</p> <p>Хувь хүний болон мэргэжлийн хувьд ахиц дэвших гаргах: Улс орны эдийн засгийн бодлогод бодитой хувь нэмэр оруулах боломжтой болох; тасралтгүй суралцах, эрдэмтэн судлаач, мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах боломж нэмэгдэх</p> <p>Дээрх бүгдийг нэгтгэн товчоор авч үзвэл: Мөнгөний бодлогын хороонд ажилласнаар улс орны эдийн засгийн ирээдүйд шууд нөлөөлөх боломжтой юм. Өөрийн мэдлэг туршлагаа ашиглан эдийн засгийн тулгамдсан сорилтуудыг даван туулах, тогтвортой өсөлтийг бий болгох, санхүүгийн тогтвортой байдал, нийгмийн сайн сайхныг дэмжих явдал юм.</p> <p>2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Бямбажавын Энх-Амгалангийн ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзлээ.</p>
--	--

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГАД НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	<p>Эцэг/эхийн нэр: Нинжбат Нэр: Ууганбаатар Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Эдийн засгийн байнгын хороо</p>
2	<p>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</p> <p>Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга</p>
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:	
<p>Төв банк/Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хяналтын зөвлөл нь дарга, 6 гишүүнээс бүрдэнэ. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны санал болгосноор Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилж, чөлөөлнө.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн</p>	

сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна." гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.

1/Нэр дэвшигч Нинжбатын Ууганбаатар нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвших тухай хүсэлт"-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2/2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу "Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай" тогтоолыг баталж, 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Рэнчинбямбын Сэддоржийг томилсон.

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:

-Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, see.mn, soronznews.mn, шогч.мн, ubn.mn, ulsturch.mn, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио, ТВ25 телевизүүдээр 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн.

4/Мэдээллийн дагуу сонсголд оролцохоор оролцогч бүртгүүлээгүй болно.

5/Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09.00 цагт Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Дав.Цогтбаатар, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж, ирц бүрдсэн болно.

6/Нэр дэвшигч Н.Ууганбаатар нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Л.Соронзонболд, Б.Жаргалан, П.Сайнзориг, Ж.Алдаржавхлан нар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл: Нэр дэвшигчийн зүгээс бусад нэр дэвшигчдэд холбогдуулан улс төрийн шинж чанартай дүгнэлт хийж байгаа үндэслэл, шалтгаан нөхцөлийн талаар;

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд: Нэр дэвшигч нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа нь Монголбанкны Хяналтын

зөвлөлийн даргаар томилогдсон тохиолдолд бодлогын болон ашиг сонирхлын зөрчил үүсгэх эсэх, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журамтай танилцсан эсэх, журмын хүрээнд сайжруулах шаардлагатай үйл ажиллагаа, Монголбанкны бүтэц орон тоо, одоо ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын тоо нь үйл ажиллагааны бүтээмж, үр дүнтэйгээ хэр уялдсан гэж үздэг талаар;

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Монголбанкны Хяналтын зөвлөлд орж ажиллах нь зохистой эсэх, Монголбанкны Хяналтын зөвлөл нь Монголбанканд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, тайлагнал дээр хяналт тавих байтал нэр дэвшигч хүсэлт, танилцуулгадаа Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны үйл ажиллагааны талаар дурдсанаас үндэслэн Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвшиж байгаа нь оновчтой эсэх, нэр дэвшиж байгаа албан тушаалынхаа чиг үүргийн хүрээнд Монголбанкны үйл ажиллагааны талаар нээлттэй болгоход ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зорьж байгаа талаар;

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг: Нэр дэвшигчийн Монголбанкны хаалттай байдал, харилцан хамааралтай байдалтай холбогдуулан хийсэн дүгнэлтийнх нь талаар, нэр дэвшигч нэг дор олон ажил, мэргэжлийг давхар хашиж байгаагаас үндэслэн одоо нэр дэвшиж буй албан тушаалынхаа хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай цаг хугацааг зарцуулах боломжтой эсэх, эдгээр асуудалд хариуцлагатай хандах шаардлагатай талаар;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх үед дүгнэлтээ гаргасан боловч төсөвт учрах эрсдэлийн талаар хангалттай тайлбарлаж ажиллаагүй, хариуцлагагүй хандсан талаар асуулт асууж, хариулт авлаа.

8/Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны онцлогийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргад нэр дэвших болсон шалтгаан нөхцөлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нийтийн албан тушаалтанд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай хугацаа олгогдох ёстой тул нэр дэвшигч Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаа дагнан эрхлэх нь зүйтэй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл нэр дэвшигчийн хандлага, ёс зүйн асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай цаашид хандлагаа анхаараад ажиллах нь зүйтэй бөгөөд хөндлөнгийн байр суурьтай хяналтыг Монголбанканд бий болгох талаар, Б.Мөнхсоёл бие даасан байр суурь бүхий, шинжлэх ухаанч байдлаар ажилд хандах боломжтой талаар үг хэлсэн болно.

9/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж хааж үг хэлсэн.

10/Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга, сонсгол даргалагч Рэнчинбямбын Сэддорж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу сонсголын тайланг Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх талаар танилцуулав.

3	<p>Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь <i>/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар/</i></p> <p>Төв банк/Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хяналтын зөвлөл нь дарга, 6 гишүүнээс бүрдэнэ. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны санал болгосноор Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилж, чөлөөлнө.”, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид "Байнгын хороо" гэх/ явуулна.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 09:00 цагт Төрийн ордны “Их засаг” танхимд зохион байгуулав.</p> <p>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.</p>
